



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 111

Номгон

Аймгийн баяр наадам болон Баянхонгор сум
байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэх өдрийг товлох,
зохион байгуулах аймгийн болон салбар хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндэсний баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.3, Засгийн газрын “Баяр наадмыг тэмдэглэх хугацааны тухай” 2017 оны 183 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монголын тулгар төрийн 2226 жилийн ой, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Баянхонгор сум байгуулагдсаны 60 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг 2017 оны 07 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Монголын тулгар төрийн 2226 жилийн ой, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Баянхонгор сум байгуулагдсаны 60 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах аймгийн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Г.Батжаргал-Аймгийн Засаг дарга

Орлогч дарга: Ж.Мөнхсоёл-Баянхонгор сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Б.Батсуурь-Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Ц.Дашцэрэн-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

М.Батбаяр-Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга

М.Өнөржаргал-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Д.Уранчимэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

С.Байгалмаа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Ихбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

0117259

Л.Баясгалангомбо-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Г.Төртогтох- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Б.Оюутболд- Аймгийн Цагдаагийн газрын дарга

Б.Энхбаатар-Цэргийн штабын дарга

3. Баяр наадмын салбар хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

4.1. Баяр наадмын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, удирдлагаар хангаж ажилласугай.

4.2. Баяр наадамд оролцох тээврийн хэрэгслийн тусгай зөвшөөрлийн хураамжаас төвлөрсөн орлогыг баяр наадмын хэв журмын арга хэмжээнд зарцуулж баяр наадмыг зохион байгуулсугай.

5. Хариуцсан салбар хороог удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг баяр наадмын салбар хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР